

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/003-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азантунгалаг
Утас: 7033-3019
Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн батлагдсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. Аудитын тайлан.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Санхүүгийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. Аудитын илрүүлэлт	7
5.1 Албан шаардлага	7
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.Аудитын санал дүгнэлт

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139, Утас/Факс: (976) 7033 3141, Цахим шуудан: arhangai@audit.gov.mn	<p>ХАЙРХАН ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА Г.НЯМ-ОЧИР ТАНАА</p>
<p>2025.03.15 № 147 танай _____-ны № _____-т</p>	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.</p> <p>Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. Тайлант оны эцэст 92,201.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;2. 2024 оны бизнес төлөвлөгөөгөөр орлого, зарлага, ашиг алдагдлыг үндэслэлтэй тооцож батлаагүй, зорилтот түвшнээс 33,027.1 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлж, 60,805.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан;3. Тайлант хугацаанд бодит хэрэгцээнээс 24,896.2 мянган төгрөгийн нүүрс илүү худалдан авч нөөцөлсөн; <p>Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай</p>	

хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Хайрхан сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9.1 дэх заалтыг зөрчсөн бөгөөд тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	763,177.41	857,329.92
1.1.2	Дансны авлага	33,295,789.46	5,397,076.17
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	494,000.00	27,888.20
1.1.6	Бараа материал	15,170,059.59	39,830,312.57
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	49,723,026.46	46,112,606.86
1.2.1	Үндсэн хөрөнгө	87,118,895.83	77,930,538.17
1.2.2	Биет бус хөрөнгө	441,185.75	770,283.06
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	87,560,081.58	78,700,821.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	137,283,108.04	124,813,428.09
2.1.1.1	Дансны өглөг	42,998,773.00	82,075,923.15
2.1.1.2	Цалингийн өглөг	-	1,392,506.00
2.1.1.3	Татварын өр	11,197,236.06	15,529,657.37
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	3,533,658.17
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	54,196,009.06	102,531,744.69
2.2	Өр төлбөрийн нийт дүн	54,196,009.06	102,531,744.69
2.3.9	Хуримтлагдсан ашиг	83,087,098.98	22,281,683.40
2.3.11	Эздийн өмчийн дүн	83,087,098.98	22,281,683.40
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	137,283,108.04	124,813,428.09

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	305,471,470.49	296,222,954.55
02	Борлуулалтын өртөг	133,354,441.92	-
03	Нийт ашиг (алдагдал)	172,117,028.57	296,222,954.55
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	223,428,616.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	121,608,363.01	127,562,504.12
12	Бусад зардал	-	6,037,250.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	50,508,665.56	(60,805,415.58)
19	Орлогын татварын зардал	5,050,866.55	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	45,457,799.01	(60,805,415.58)
22	Тайлант үеийн ашиг (алдагдал)	45,457,799.01	(60,805,415.58)
24	Орлогын нийт дүн	45,457,799.01	(60,805,415.58)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-	-	83,087,098.98	83,087,098.98
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	-	-	-	(60,805,415.58)	(60,805,415.58)
3	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-	-	22,281,683.40	22,281,683.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	318,664,702.84	325,775,596.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	318,664,702.84	325,775,596.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	273,722,725.43	325,131,443.49
1.2.1	Ажиллагчдад төлсөн	81,739,970.50	75,061,747.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	25,682,224.56	26,039,670.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	84,216,061.52	147,075,560.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	24,992,344.69	36,432,465.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,587,630.00	13,179,070.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,209,704.70	15,304,530.15
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,294,789.46	12,038,400.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,941,977.41	644,152.51
2.2	Мөнгөн зарлагын дүн	44,488,900.00	550,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,488,900.00	550,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,488,900.00	(550,000.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	453,077.41	94,152.51
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	310,100.00	763,177.41
7	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	763,177.41	857,329.92

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа¹ илрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 181,236.3 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 6 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 5 зөрчилтэй асуудал нь 181,236.3 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 1,925.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант хугацаанд бодит хэрэгцээнээс 24,896.2 мянган төгрөгийн нүүрс илүү худалдан авч өр төлбөр үүсгэж нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагагүй бараа материалыг үр ашиггүйгээр удаан хадгалах шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал нөөцлөхгүй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

3.1.2 "Галт зүрх" ХХК-нд төлөх 38,500.0 мянган төгрөг, "Соронзон сувд" ХХК-ний нүүрсний өглөг 39,575.9 мянган төгрөг, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 1,647.4 мянган төгрөг, Нүүрс худалдан авахтай холбоотой НӨАТ-ын 7,073.5 мянган төгрөгийн нийт 86,796.8 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү,төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3 "Соронзон сувд" ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 2024/17 дугаартай гэрээ байгуулсан ба нийт 77,575.9 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна. Соронзон сувд ХХК нь борлуулсан нүүрсний НӨАТ-ын падааныг цахим системд шивээгүйтэй холбоотой 7,052.4 мянган төгрөгийн НӨАТ-ын өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү,төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” 14.4-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг баталгаажуулсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэмэгдсэн өртгийн албан татварын падааныг үндэслэн албан татварын хасалтыг хийнэ” Нүүрс нийлүүлэх 2024/17 дугаар ажлын гэрээний 2.6-д “Гэрээний 1.3-д заасан нөхцөлөөр нийлүүлэх 1 тн нүүрсний үнэ 217,965 төгрөг байх бөгөөд үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар, талбайн ачилт, буулгалт, тээвэрлэлт ажлын хөлс бүгд багтсан болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.4 Тайлант онд бизнес төлөвлөгөөг Сумын Засаг даргаар батлуулаагүй бөгөөд бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангаагүй 60,805.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 21.1.4 “санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг” тусгана, сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Хайрханы хөгжил дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9.1-д “Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх, ажил зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.5 Үйлчилгээний хөлсний 2022 оны авлагын үлдэгдэл 1,685.6 мянган төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.6 Тус байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс дотоод хяналт хэрэгжүүлээгүй 2024 оны бизнес төлөвлөгөөг 64,413.7 мянган төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна”, сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Хайрханы хөгжил дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.5-д “Газарт сумын ИТХ-ын тогтоолоор баталсан ТУЗ төлөөлөл хэрэгжүүлэх, арга зүйн удирдлагаар ханган ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-д “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын бизнес төлөвлөгөөг ашигтай байхаар баталж, үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Бараа материал нөөцөлсөн	1	24,896.2			1	24,896.2							
Өр төлбөр үүсгэсэн	1	86,796.8			1	86,796.8							
НӨАТ өр төлбөр үүссэн	1	7,052.4			1	7,052.4							
Бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй батлаагүй	1	60,805.4			1	60,805.4							
Авлага барагдуулаагүй	1	1,685.6			1	1,685.6							
ТУЗ-д хяналт хэрэгжүүлэх.	1	-			1	-							
Дүн	6	181,236.3			6	181,236.3							